

**НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчдын нөхцөл байдлын Тусгай илтгэгч ноён Форст  
2019 оны 4-р сарын 30-аас 5-р сарын 13-ний өдрүүдэд  
Монгол Улсад албан айлчлал хийхээр товлосныг тохион санал хүсэлтээ ирүүлнэ үү**

НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчдын нөхцөл байдлын Тусгай илтгэгч ноён Форст 2019 оны 4-р сарын 30-аас 5-р сарын 13-ний өдрүүдэд Монгол Улсад албан айлчлал хийнэ. Айлчлалын үеэр Тусгай илтгэгч Засгийн газрын төлөөлөл, орон нутгийн засаг захиргаа, хүний эрхийг хамгаалагчид, иргэний нийгмийн төлөөлөл болон бусад талуудтай уулзаж Монгол дахь хүний эрхийн хамгаалагчдын хуримтлуулсан сайн туршлага, мөн тэдэнд тулгардаг сорилт, бэрхшээлүүдийн тухай ярилцна.

Тусгай Илтгэгч нь Монгол улсад хийсэн айлчлалын тайлангаа 2020 оны 3-р сард НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд олон нийтэд нээлттэйгээр танилцуулна.

Энэхүү айлчлалаар хэлэлцэх асуудлуудад хувь нэмрээ оруулах сонирхолтой хүмүүс дараахь асуултуудын хүрээнд санал бодлоо бидэнд урьдчилан илгээнэ үү? Энэ боломжийн тухай сонирхсон хувь хүн, талуудад мэдээллийг хүргэнэ үү? Хариултуудын нууцлалыг сахих болно.

**Хүний эрхийг хамгаалагч, иргэний нийгмийнхэн болон бусад сонирхогч талууд дараахь асуудлаар ерөнхий мэдээлэл, мөн тодорхой саналаа бидэнд ирүүлнэ үү?**

**Ерөнхий нөхцөл байдал** (Хүний эрхийг хамгаалагчдын ажилд нөлөөлж буй дотоодын хууль тогтоомж, бодлогуудыг нэрлэнэ үү? Эдгэртэй холбоотой ямар сайн жишээ, сорилтууд байдаг вэ? Эдгээр хууль, бодлогууд бодит амьдралд хэрхэн хэрэгждэг вэ? Бизнес, хувийн хэвшлийн салбарынхан хүний эрхийг хамгаалагчдын ажлыг хэр их хүлээн зөвшөөрч, хүндэтгэдэг вэ?)

**Анхаарах асуудлууд** (Хүний эрхийг хамгаалагчдын ажилд нөлөөлж буй хамгийн гол мөн хамгийн тулгамдсан ямар асуудлууд байна? Эдгээр асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх вэ?)

**Улаанбаатар хотоос гадна өөр ямар газар очихыг зөвлөж байна вэ** (очих байршил эсвэл уулзах хамт олон)?

**Тусгай Илтгэгчийн Монгол улсад хийх айлчлалын хүрээнд уулзахыг зөвлөж буй засаг захиргааны төлөөлөл, байгууллагууд, хувь хүмүүсийг нэрлэнэ үү?**

Засаг захиргааны төлөөлөлтэй уулзахад нь ямар **тодорхой асуудлыг хөндөж, хэлэлцэхийг** Тусгай илтгэгчид зөвлөж байна вэ? Тусгай илтгэгчийг анхааралдаа аваасай гэсэн тодорхой **зөвлөмжүүд** бий юу?

Хариултуудыг 1-2 хуудсанд батгааж [defenders@ohchr.org](mailto:defenders@ohchr.org) цахим хаягаар **4-р сарын 2-ны өдрөөс хэтрүүлэхгүй** илгээнэ үү? Таны хариулт, саналууд 5-р сарын 13 –аас хойш ирвэл хөндсөн асуудлуудыг айлчлалын үеэр хэлэлцэх боломжгүй болохыг анхаарна уу. Харин хариултуудыг Тусгай Илтгэгчийн НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд толилуулах тайландаа тусгах болно. Лавлах асуулт байвал бидэнтэй [defenders@ohchr.org](mailto:defenders@ohchr.org) цахим хаягаар холбогдно уу?